

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ОРОС ЗӨВЛӨХ ТҮШМЭЛТЭЙ БОЛСОН ТҮҮХ

Г.Цэнджав

ШУТИС-ийн багш, докторант

Ар Монгол дахь 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ялалт нь Монголын ард түмэнг эрх чөлөөтэй болгосон түүхэн чухал үйл явдал байлаа. Өмнөт Монгол харь Манж Чин улсад эзлэгдсэнээс хойш 275 жил, Халх Монгол 220 жил, Баруун Монгол 154 жилийн дараа тийнхүү Манжийн эрхшээлийг таягдан хаясан юм. Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь Монгол төрийнхөө тусгаар тогтнолоо сэргээн тунхаглах, улмаар нийт газар нутгаа манж-хятадын цэргээс чөлөөлж нийт Монгол овогтноо нэгтгэсэн Их Монгол улсыг байгуулах зорилготой байлаа. Энэхүү хоёр зорилтын эхнийхэн амжилттай хэрэгжсэн билээ.

Монгол төрийнхөө тусгаар тогтнолыг сэргээх хувьсгалт үйл явц Их Хүрээнд тайван замаар хийгдэж, харин Ар Монголын Баруун хязгаарыг манж-хятадын цэргээс чөлөөлөх үйл явц зэвсэгт тэмцлийн замаар хийгдсэн юм. Харин Ар, Өвөр Монголоо нэгтгэх гэсэн үйл явц Монголын тусгаар тогтнолын талаар хоёр хөрш орон болох: Хаант Орос болон Дундат Иргэн улсын баримталж байсан бодлогын улмаар тасалдан, бүтэлгүйтсэн түүхтэй.

Монголчууд төрийнхөө тусгаар тогтнолыг сэргээх их үйлстээ хойт хөрш Хаант Орос улсыг өмөг түшэг нь болно хэмээн найдаж, түүн рүү хандсан байна. 1911 оны намар Манжийн зүгээс Монгол орныг илт колоничлох гэсэн “Шинэ засгийн бодлого” гэгчийг 1901 оноос явуулж эхлэхэд Орос улс руу хандаж, энэхүү харгис бодлогыг таслан зогсоохын төлөө тэмцэхэд тусламж эрсэн юм. 1911 оны намар чин ван Ханддорж, да лам Цэрэнчимид, өвөрлөгч түшмэл Хайсан зэрэг хүмүүсийг Хаант Оросын нийслэл Петербург хотноо сэм илгээж, тусламж хүссэн байна. Чингэхэд Орос улс Манж Чин гүрний эсрэг тэмцэн босох цаг нь болоогүй, тохиромжтой цаг мөчийг хүлээх хэрэгтэй, харин Чин гүрний зүгээс Монголыг илт колоничлох гэсэн “Шинэ засгийн бодлогыг” болиулах талаар Оросын эзэн хааны Засгийн газар, Манжийн Засгийн газартай дипломат ярилцлага хийж, тус хүргье гэсэн хариу барьсан байдаг. Тусгаар тогтнолын үйл хэрэгт тус дэм болох болов уу? гэж найдан түүн рүү хандсан байхад, ийм хариу өгсөнд Монголын эрх баригчид туйлийн сэтгэл дундуур байсан бөгөөд тухайн үеийнхээ улс төрийн нөхцөл байдалд маш зөв үнэлэлт дүгнэлт өгөөд бидний өвөг дээдэс харийн эрхшээлээс гарах тэмцэлд даан өөрийн хүчээр эрслэн босч, үндэсний эрх чөлөөгөө байлдан олж авсан юм.

Үндэсний анхдугаар хувьсгалаар тогтоосон шинэ тулгар Монгол улсаа цаашид хөгжүүлэн, хөгжлийн хоцрогдлыг арилгахын тулд Монгол Улсын Засгийн газар ихээхэн зүйлийг сэдэн хийж эхэлсэн байдаг.

Тулгар төрийнхөө тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг баталгатай болгох, тусгаар тогтнолоо гадаад орнуудаар хүлээн зөвшөөрүүлэх, нийт Монголоо нэгтгэх үйл хэрэг болон нийгэм-эдийн засгийн олон чухал үйл хэргийг цаашид

амжилттай хэрэгжүүлхэд тус оронд мөнгө, зэр зэвсэг ихээхэн хэрэгцээтэй байлаа. Тиймээс Хаант Оросоос зээл авахыг удаа дараа хүссэн байна.

Монголд цагагчин гахай жилийн (1911 он) хувьсгал ялмагц Хаант Орос улс нэгэн зэрэг хэд хэдэн асуудлыг шийдэхэд хүрчээ. Үүнд:

- ✓ Оросын туслалцаа дэмжлэгт найдаж буй монголчуудад туслах,
- ✓ Хятадтай хэвийн харилцаатай байхын зэрэгцээгээр
- ✓ Монголд өөрийн эрх ашгийг хангах зэрэг болно.

Нэгдэх болон гуравдах зорилтыг биелүүлэхийн тулд Монголын Засгийн газрын дэргэд зөвлөх түшмэлийг илгээх санаа төржээ. Өгүүлэн буй үед Монголд Консулын (Нийслэл Хүрээ, Ховд, Улиастайд- гэсэн гурван консулын газар байв) газрын ажилтнуудаас гадна “Монгол бригад”-ын офицер болон бага дарга нар монгол цэргийг сургаж байсан бөгөөд мөн Нийслэл Хүрээнд Хаант Оросын Худалдаа аж үйлдвэрийн яамны төлөөлөгч сууж, Монголтой хийх худалдаа арилжаа наймаа, тус орноос худалдаан авах мал, түүхийн эдийн асуудлыг хариуцаж байжээ. Дашрамд дурьдахад Хаант Орос нь Солонгос улс руу мөн л цэргийн зөвлөх болон санхүүгийн зөвлөхүүдийг илгээж байсан байх юм.

Монголын 1911 оны хувьсгал нь нэг нийгмийн байгуулалыг нөгөө нийгмийн байгууллалаар сольсон Нийгмийн хувьсгал биш байв. Энэ нь үндэсний эрх чөлөөний төлөөх хувьсгал байсан бөгөөд Монгол улс нь хамжлагын харилцаа ноёрхсон нийгмийн байгуулалтай хэвээрээ байв. Эл үед дан ганц амиа аргацаасан нүүдлийн мал аж ахуйтай, хуримтлал байхгүй, үйлдвэрлэл-худалдаа сул хөгжиж байсан явдлаас улбаалан Монгол улс нь нийгмийн хөгжлийн арай дээд шатанд гарах боломж байсангүй. Гэхдээ Монголын төрөөс улс орноо хөгжүүлж, олон жилийн түгжигдмэл байдлаас үүссэн хөгжлийн хоцрогдлыг арилгах талаар эрчимтэй бодлого хэрэгжүүлж эхэлсний ачаар Монголын нийгэм хөдөлгөөнд орж байлаа. Улс орныхоо тусгаар тогтнолыг цаашид батлан хадгалан үлдэх, нийгэм-соёлоо хөгжүүлхэд тус оронд мөнгө, хуримтлал хэрэгтэй байлаа.

Мөнгөний гачаалал байсан учраас Монголын Засгийн газар Хаант Оросоос зээл хүсэх болов. Чингээд хэд хэдэн удаа Оросоос зээл тусламж хүсэх болсон бөгөөд түүнийгээ ариг гамгүй хэрэглэж байгаагийн улмаас өгч буй зээлийн зарцуулалтанд хяналт тавих, өгсөн зээлээ нөхөн төлөгдөх явдлыг хангах болон мөн түүнчлэн Монголын эрх баригчид “манай дотоод хэрэг” гэдэг нэрийн доор өөрийн орны бүхий л асуудалд оросуудыг оролцуулахгүй, нуун далдалж байгаа явдал зэргээс улбаалж дээрхи асуудал тавигдах болжээ. Өгч буй зээлийн зарцуулалтанд хяналт тавих асуудал анх 1912 онд 2 сая рублийг цэргийн болон засаг захирагааны шинэчлэлд зориулахаар 40 жилийн хугацаатай зээллэг хүсэх үед яригдаж эхэлжээ. 1912 оны эцсээр Хаант Оросыг зорьсон Гадаад явдлын яамны сайд, хошой чин ван Ханддорж тэргүүтэй Монгол улсын элч төлөөлөгчид Санкт Петербургт аичлахдаа дээрхи зээлийг хүссэн байдаг.

1912 оны намар Нийслэл Хүрээнд Орос-Монголын найрамдлын гэрээ байгуулагджээ. Үүний дараа дээрхи Ханд ван тэргүүтэй төлөөлөгчид Хаант

Оросыг зорьсон юм. Орос-Монголын найрамдлын гэрээг байгуулхаар Оросоос хүрэлцэн ирсэн И.Я.Коростовцийн мэдээлснээр: "... Монголын эрх баригчид хяналт тавих асуудлыг огт зөвшөөрөхгүй... тэд бага хэмжээний зээл өгсөн ч болно гэж байна. Тиймээс бид "Монголор"-ын орлого, эсвэл гаалийн орлогыг нь барьцаалан зээл олгож, чингэхдээ эдгээрт тавих хяналтыг Консулын газарт эсвэл шинээр буй болгох албан тушаалтны тусламжтайгаар далдалсан хяналт тавьж болох юм" ⁷⁷ гэсэн баримтыг түүхч Ж.Урангуа "XX зууны эхэн үеийн Монгол Улс" бүтээлдээ дурьдсан байна. ⁷⁸



И. Я. Коростовец

Иван Яковлевич Коростовец (1862—1933) Оросын дипломат, Дорнодахин судлаач

И.Я. Коростовец 1913 оны 5 дугаар сарын 5-ний өдөр Гадаад хэргийн яамандаа ийнхүү мэдээлжээ: "Тэднээс бидэнд нэмэлт болгон өгсөн улсын орлого, зарлагын тухай мэдээ сэлт нь туйлын хангалтгүй, Монголын төсөвийн талаар там тум төсөөлөл өгөх зүйл байна. Одоогийн нөхцөлд Хүрээний Засгийн газар бидний сонирхож буй асуудлаар үүнээс илүү зүйл өгч чадахгүй бололтой. Да лам⁷⁹ болон Хятадын талыг баримтлагч ноёд бидний эсрэг элдэв явуулга хийж байна. Би монголчуудад, өгсөн мэдээлэл шаардлага хангахгүй байгаа нөхцөлд зээлийн асуудал та нараас өөрсдөөс чинь болон сунжирч байна гэж хэлэхийн зэрэгцээ таны мөнгөний хэрэгцээнд нааштай хандахад Орос санхүүгийн зөвлөх авчирч санхүүгээ цэгцэлвэл зохилтой байна гэдгийг би монголчуудад ойлгуулсан" гэж мэдээлжээ. Үүнээс үзвээс Монголын тал санхүүгийн зөвлөхийг зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд хүрчээ.

Монголын Засгийн газар буулт хийж, санхүүгийн зөвлөх авах тухай асуудал тавих болсон тухайд Коростовец 1913 оны 5 дугаар сарын 8-ний өдөр Гадаад яамандаа: "Монголчууд санхүүгийн хэргээ цэгцлүүлэх үүднээс Оросоос

⁷⁷ Российский государственный исторический архив. Ф-1276, Дело 463, стр. 413. Секретная Телеграмма действительного статского советника Коростовца. Урга 8\21 окт. 1912 № 175

⁷⁸ Урангуа Ж. XX зууны эхэн үеийн Монгол улс (1911-1919 он) УБ., 2006, т.99

⁷⁹ Да лам Цэрэнчимид-Монгол улсын Дотоод яамны тэргүүн сайд

санхүүгийн зөвлөх авах асуудлыг надад албан ёсоор тавив. Тэд Монгол орныг сайн мэдэх бөгөөд тэдний итгэлийг хүлээсэн Сангийн яамны түшмэл Котвичийг авах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв” хэмээн мэдэгджээ. Гэвч В.Л.Котвич гэр бүлийн байдлаас хэмээн өөрөө татгалзан, эл албанд ажиллах боломжгүй хэмээн мэдэгдсэн байна. Тийнхүү Монголын талын хүссэн хүн ирэх боломжгүй болжээ..

Ингээд Монгол улсад санхүүгийн зөвлөхөөр ажиллах хүнээр Оросын Сангийн яамны сайд В.Н.Кокковцев Сергей Андреевич Козины нэрийг дэмжин дэвшүүлж, улмаар тэрээр Монгол улсын Засгийн газрын сангийн хэргийн зөвлөх түшмэлээр томилогдохоор болсон юм. Гэвч зөвлөх илгээх тухай Монголын Засгийн газартай хийх хэлэлцээр удааширжээ. Ерөнхий сайд Сайн ноён хан эл үеэр өвдсөн учир эл асуудлыг 1913 оны 8 дугаар сард ерөнхий сайдыг Орост айлчлах үе хүртэл хүлээзнэх саналыг Монголын тал тавьж байлаа. Эл байдалд Оросууд тун дурамжхан хандаж, Оросын Гадаад хэргийн сайд А.А.Нератов долоодугаар сарын 18-нд Нийслэл Хүрээн дэх Ерөнхий консулд цахилгаан илгээж Козиныг хүлээн авах асуудлыг яаравчлуулах хэрэгтэй байна гэдгийг сануулж байжээ. Ингээд 1913 оны 10 дугаар сард Сайн ноён хан тэргүүтэй Монгол Улсын элч төлөөлөгчид Санкт Петербургт айлчлах үеэр буюу мөн оны 12 дугаар сарын 26-ны өдөр ерөнхий сайд Намнансүрэн, С.А.Козин нар Монголд санхүү болон иргэний шинэтгэлүүдийг хийх гэрээ байгуулсан ажээ⁸⁰.

Ингэж Монголын тал зөвлөх түшмэл урих асуудлыг Хаант Оросын шахалт доор хүлээн зөвшөөрсөн бөгөөд Оросын Засгийн газраас томилсон С.А.Козинтэй (хувь хүнтэй) гэрээ бичиг солилцожээ.

Ерөнхий сайдын дээрхи айлчлалаар Монгол улс Хаант Орос улсаас 3 сая рублийн зээл хүссэн бөгөөд энэ байдлыг Оросын тал маш чадамгай ашиглан монголчуудын дунд нэвтрэн орж, бүхий л салбарт нь хяналт тавих, хойш нь мэдээлж байх үүрэг бүхий төлөөлөгчийг илгээж чадсан аж. Монголд туслах нэрийн дор өгч буй зээлийнхээ эргэн төлөгдөх нөхцлийг ч буй болгоход чиглэж байв.

Монгол улсын хувьд бол мөнгө санхүүгийн гачигдалтай байдлынхаа улмаас тийнхүү Хаант Оросоос зөвлөх түшмэл авах байдалд хүрчээ. Зөвлөх нь 1914 оны 5 дугаар сард Монголд хүрэлцэн ирээд 1917 оны цагаан сар хүртэл тус орны Засгийн газарт зөвлөх түшмэлээр ажилласан байна.


Санхүүгийн зөвлөхийн үүрэг нилээд өвөрмөц байв. Учир нь тэрбээр Ерөнхий консулаас нууцаар удирдамж авахын зэрэгцээгээр, хэрэг дээрээ Монголын Засгийн газрын зааврын дагуу ажиллаж буй бие даасан этгээд мэтээр харагдаж, монголчуудын итгэл найдварыг олж авах ёстой байжээ. Санхүүгийн зөвлөхийн үйл ажиллагааны улс төрийн талыг авч үзвэл тэрээр түүнд удирдамжийг Гадаад хэргийн яам нь өгч, санхүү болон засаг захиргааны үйл ажиллагаанд нь Сангийн яаманд нь хамаарч байжээ. Санхүүгийн зөвлөхийн бүхий л үйл ажиллагааны тайлан, мэдээлэл болон түүний ажил төрлийн талаарх

⁸⁰ УТА ФА—4, ХН—673 “Монгол улсын Богд эзэн хааны засгийн хэрэг шийтгэх газраас Орос улсын харъяат Сергей Андреевич Козинтай хэлэлцэн тогтоосон гэрээ бичгийн зүйл (§12)

консулын мэдээлэл зэрэг баримтууд өдгөө Оросын архивуудад хадгалагдаж байна.

Монголд Зөвлөх түшмэлээр томилогдон ирсэн Сергей Андреевич Козин (1879-1956) хэл шинжлэлийн ухааны доктор, профессор, ЗХУ-ын Шинжлэх ухааны Академийн жинхэнэ гишүүн. 1903 онд Петербургийн Их Сургуулийн дорно дахины хэлний факультетыг төгссөн. С.А. Козин 30 гаруй бүтээл туурвисан нь үлгээр-туульс судлалын чиглэлээр юм. Тэрээр "Монголын нууц товчоо", "Гэсэрийн тууж", "Жангарын тууль" зэргийг оросоор орчуулж, тайлбартай хэвлүүлсэн. "Монголын ард түмний туульс", "Орос-Монгол толь" зэрэг бүтээлүүд туурвисан бөгөөд Зөвлөлт-Монголын эрдэмтэдийн хамтын бүтээл "БНМАУ-ын түүх" нэгэн боть зохиолын редакцийн зөвлөлд байсан монголч эрдэмтэн юм. 1936 онд Ардын хувьсгалын 25 жилийн ойн медалиар шагнуулсан байдаг.

Зөвлөх түшмэлийн орлогчоор П.А.Витте ажилласан юм. Тэрээр Козинтой хамт Астрахань мужид ажиллаж байсан бөгөөд Козины санаачлагаар 1915 оноос зөвлөх түшмэлийн хөдөө аж ахуй хариуцсан туслахаар ажилласан байна.



Козин, Витте нар Монголд 1916 он

Түлхүүр үг: Эрх чөлөө, тусгаар тогтнол, хөрш улсуудын бодлого үйл ажиллагаа, санхүүгийн зөвлөх түшмэл, монгол орныг судлах экспедиц, улсын төсөв.

Товч хураангуй: Монгол улс үндэсний эрх чөлөөний тусгаар тогтнолоо 1911 оны 12-р сарын 29-нд тунхагласаны дараагаас цаашид улс орныхоо тусгаар тогтнолыг улам батжуулах зрилгоор хөрш улс болон, гуравдагч орнуудтай улс төр эдийн засгийн харилцан ашигтай, найрамдалтай харилцах саналыг төр засгийн хэмжээнд тавьж байлаа. Гагцхүү үүнд Оросын талаас Монголын талаар баримтлах бодлого үйл ажиллагаанд илүү идэвхтэй байр сууринаас хандах болов. Оросын засгийн газар Монголын эрх баригчдын удаа дараагийн хүсэлтийн дагуу зээл

тусламжийн асуудлыг өөртөө ашигтайгаар шийдвэрлэх үүднээс олон зүйлийн арга хэмжээнүүдийг шат дараалан авч байлаа. Уг өгүүлэлд Оросын талаас монгол улсын засгийн газарт зөвлөх түшмэл гэсэн шинэ албан тушаалтныг бий болгож, улмаар уг түшмэлүүдээр дамжуулж Монголын эдийн засгийн нөөц баялгийг хяналтандаа оруулах болсон. Мөн Хятадын эдийн засгийн хүчтэй нөлөөг аажмаар шахаж, өөрийн монополь эрхээ тогтоохын тулд Монголд олон олон судалгааны экспедицүүдийг оруулж ирүүлсэн байна. Үүнээс С.А. Козины явуулсан үйл ажиллагааны талаарх мэдээ материалуудыг голлон дурдлаа.

ABSTRACT

After Mongolia has announced its independence of national freedom on the 29th day of December, 1911, our country had started putting forward proposals to the neighboring and third countries to cooperate mutually efficiently and peaceably in order to strengthen its independence. But exclusively only Russia had applied the active position on activities and policy on Mongolia. According to request of power holder rulers of Mongolia the Russian Government had started taking different kinds of measures gradually in order to resolve loan and aid issues in their favor. In this article the issues about how the Russian government created new position of an Russian advisor for the Mongolian Government, how they started to control Mongolian economic resources through those officials, how they constrained the powerful influence of Chinese economics gradually and penetrated a number of Russian research expeditions to Mongolia in order to create their monopoly. Also this article is included the materials related to actions conducted by S.A. Kozin.

НОМ ЗҮЙ

1. Л. Жамсран "Монголын сэргэн мандалтын эхэн"/1911 -1913 он УБ.1992/
2. Ж.Урангуа "Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс" УБ.2010
3. Ж.Урангуа "XX зууны эхэн үеийн Монгол улс" УБ.2010
4. Е.М. Даревская "Сибирь и Монголия. Очерки русско-монгольских связей в конце XIX-начала XX веков. Иркутск 1994
5. Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ /өдөр тутмын тэмдэглэл/ эмхэтгэсэн О. Батсайхан УБ.1999
6. www.google.mn
7. А.М.Майский "Орчин үеийн монгол " УБ.2002